



ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИХ СУРГУУЛЬ



ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА – 2019

www.nucb.edu.mn



ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

(2018-2019 оны хичээлийн жил)

Сургалтын алба

**Улаанбаатар
2019**

Гарчиг

- Оршил.....5-6
- Сургалтын нэгдсэн хуанли.....7-10
- Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн
танилцуулга.....11-17
- Оюутан суралцагчийн ёс зүйн журам17-20
- Оюутны тангараг, эрхэмлэх зүйл21
- Оюутанд үзүүлэх үйлчилгээ.....22-25
- **Сургалтын журам**25-53
- Зөвлөх багшийн үүрэг54-55
- Сургалтын төлөвлөгөө.....56-98

Оюутны тухай мэдээлэл

Овог

Нэр

Оюутны код

Мэргэжил

Утас

Оршин сууж буй хаяг

Мэйл хаяг

Зөвлөх багшийн нэр

Утас

Мэйл хаяг

Тэнхмийн эрхлэгчийн нэр

Утас

Мэйл хаяг

Оршил

Манай сургуулийн эрдмийн гэгээн өргөөнд алхан орж байгаа оюутан танд шинэ хичээлийн жилийн мэндчилгээ дэвшүүлье.

Даяаршил, мэдээллийн шинэ эринд шинжлэх ухааны өргөн бөгөөд гүнзгий мэдлэг чадвар, дадал эзэмшиж оюуны өндөр чадамж олж авах нь ирээдүйг гардан байгуулах залуус та бүгдийн бүтээлч сэтгэлгээ өөдрөг, баян амьдралд шийдвэрлэх ач холбогдолтой.

Та бүхэнд өргөн барьж буй энэхүү эмхтгэлд:

1. Мэргэжил бүрийн сургалтын төлөвлөгөө;
2. Оюутны дагаж мөрдвөл зохих гол дүрэм журмууд;
3. Сургалтын календарьчилсан график;
4. Сурах үйл ажиллагаагаа төлөвлөн үр дүнтэй ажиллахад зайлшгүй шаардлагатай зөвлөмжүүд;
5. Сургуулийн амьдралтай холбогдсон бусад материал, мэдээлэл багтсан болно.

Оюутан бүр амжилттай суралцахын тулд дараах зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна. Үүнд:

- Сонгосон мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөтэй энэ номноос сайтар танилцан, нарийвчилж ойлгох;
- Тодорхой мэргэжлийг дээд боловсролын дипломын болон бакалавр, магистрын зэрэгтэй төгсөхөд тус бүрд нь тавигдах үндсэн шаардлагыг хэрхэн тогтоосныг анхаарч үзэх;
- Ерөнхий болон мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн хоорондын уялдаа холбооны учир утгыг нягтлан мэдэх;
- Заавал судлах болон сонгон суралцах хичээлүүдийн кредит цагийн тоо тэдгээрийн харьцааг мэдэж авах нь зүйтэй;

- Та бүхний судлах хичээл бүр өөрийн код кредиттэй байгааг мэдсэн байх;
- Оюутан бүр өөрийн суралцах хувийн төлөвлөгөөгөө оновчтой зохиоход онцгой анхаарч зөвлөх багшаас тусламж авах;
- Сургалтын төлбөрөө төлсөн оюутанд сургалтын үйлчилгээ үзүүлэх бөгөөд энэ нь нарийн төлөвлөгдсөн тул түүнийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байх;
- Оюутнууд өөр өөрийн сурлагын амжилт (дүн ба голч дүн)-аа тухай бүр мэдэж сүлжээнээс шалган нягталж, ташаарал байх аваас хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж залруулах зайлшгүй шаардлагатайг ойлгох;
- “Оюутны гарын авлага”-д заагдсан шаардлага болон журмуудыг судалж үйл ажиллагаандаа сахин биелүүлэх.

Оюутан таны эрдэмд шамдах хүслээ биелүүлэхэд тань дээр өгүүлсэн бүхэн тус дэм болно гэдэгт найдаж байна.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль (ХҮИС) – ийг сонгон суралцаж, дээд боловсролтой болох гэсэн сайхан хүсэл чинь сэтгэлчлэн бүтэж, эх орныхоо хөдөлмөрийн зах зээл дээр эрдэм чадлын ганзага дүүрэн гарахын өлзий дэмбэрэлтэй ерөөлийг өргөн барья.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль
Сургалтын алба

2018-2019 оны хичээлийн жилийн
Сургалтын календарьчилсан төлөвлөгөө
Намрын улирал

Сар	Долоо хоног	Өдөр							Үйл ажиллагаа	Өдөр
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
VIII сар									Элсэх эрх авсан суралцагчдыг бүртгэх	VIII/20-24
				1	2	3	4	5	Оюутны дотуур байранд амьдрах оюутныг бүртгэх	VIII/22-29
		6	7	8	9	10	11	12	Шилжих хүсэлтийг эцэслэн шийдвэрлэнэ	VIII/20-28
		13	14	15	16	17	18	19	Хичээл сонголт баталгаажуулах	VIII/27-31
		20	21	22	23	24	25	26	Шинээр элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт, гэрээ байгуулна	VIII/27-IX/02
		27	28	29	30	31				
IX сар		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
							1	2	Хичээлийн шинэ жилийн нээлт	X/03
	I	3	4	5	6	7	8	9	Магистр, бакалаврын оройн хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл	VII/20-IX/20
	II	10	11	12	13	14	15	16	Өмнөх улирлын дүнгийн гомдол, маргаан шийдвэрлэх	IX/3-IX/28
	III	17	18	19	20	21	22	23	Магистр, бакалаврын оройн хөтөлбөрт элсэгчдийн	IX/24

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль

	IV	24	25	26	27	28	29	30	шалгалт Магистр, бакалаврын оройн хөтөлбөрт элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт, гэрээ байгуулах	IX/26- IX/28
									Магистр, бакалаврын оройн хөтөлбөрийн хичээл сонголт, баталгаажуулалт	IX/26- IX/28
X сар		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
	V	1	2	3	4	5	6	7	Магистр, бакалаврын оройн хөтөлбөрийн намрын улирлын хичээл эхэлнэ	X/01
	VI	8	9	10	11	12	13	14		
	VII	15	16	17	18	19	20	21	Явцын шалгалт	X/22- X/26
	VIII	22	23	24	25	26	27	28		
	IX	29	30	31						
XI сар		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
					1	2	3	4		
	X	5	6	7	8	9	10	11		
	XI	12	13	14	15	16	17	18	Магисрын хөтөлбөрт хаврын улиралд элсэгчдийн бүртгэл	XI/12- I/15
	XII	19	20	21	22	23	24	25	Багш дараагийн улиралд заах хичээлийн санал өгнө	XI/12- XI/16
	XIII	26	27	28	29	30	31			
XII сар		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
	XIII						1	2	Магистрын урьдчилсан хамгаалалт	XII/03- XII/07
	XIV	3	4	5	6	7	8	9	Тэнхим хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж,	XII/10- XII/23

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль

									Сургалтын алба баталгаажуулна		
	XV	10	11	12	13	14	15	16	Магистрын жинхэнэ хамгаалалт	XII/24- XII/28	
	XVI	17	18	19	20	21	22	23	Улирлын шалгалт	XII/24- I/06	
	УШ	24	25	26	27	28	29	30	Магисрын хөтөлбөрт хаврын элсэгчдийн бүртгэл	XII/12- I/15	
	УШ	31									
I сар		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Шинэ жил	I/10	
		УШ	1	2	3	4	5	6	Нэгтгэн дүгнэх	I/07- I/13	
		НД	7	8	9	10	11	12	13	Шилжилтийн бүртгэл эхлэх, баталгаажуулах	I/7-I/20
		УА	14	15	16	17	18	19	20	Магистрын хөтөлбөрт хаврын улиралд элсэгчдийн шалгалт	I/11- I/17
		УА	21	22	23	24	25	26	27	Улирлын амралт	I/14- II/03
		УА/0	28	29	30	31				Шилжих хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх	I/21- I/25
									Магистрын хөтөлбөрт элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт	I/21- I/25	
									Хаврын улирлын хичээл сонголт, баталгаажуулалт	I/28- I/03	

Хаврын улирал

Сар	Долоо хоног	Өдөр							Үйл ажиллагаа	Өдөр
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
II сар						1	2	3	Хаврын улирлын хичээл сонголт, баталгаажуулалт	I/28- II/3
	I	4	5	6	7	8	9	10	Хаврын улирлын хичээл эхэлнэ	II/4
	II	11	12	13	14	15	1	17	Шилжих хүсэлтийг эцэслэн	I/14- III/02

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль

									шийдвэрлэнэ	
	III	18	19	20	21	22	23		Өмнөх улирлын дүнгийн гомдол, маргаан шийдвэрлэх	
	IV	25	26	27	28					
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
						1	2	3		
III сар	V	4	5	6	7	8	9	10		
	VI	11	12	13	14	15	16	17		
	VII	18	19	20	21	22	23	24		
	VIII	25	26	27	28	29	30	31	Явцын шалгалт	III/25-IV/5
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
IV сар	IX	1	2	3	4	5	6	7		
	X	8	9	10	11	12	13	14		
	XI	15	16	17	18	19	20	21		
	XII	22	23	24	25	26	27	28	Багш дараагийн улиралд заах хичээлийн санал өгнө	IV/22-26
		29	30							
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
V сар	XIII			1	2	3	4	5		
	XIV	6	7	8	9	10	11	12	Магистрын урьдчилсан хамгаалалт	V/6-10
	XV	13	14	15	16	17	18	19	Тэнхим хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, Сургалтын алба баталгаажуулна	V/13-17
	XVI	20	21	22	23	24	25	26	Магистрын жинхэнэ хамгаалалт	V/20-24
	УШ	27	28	29	30	31			Улирлын шалгалт	V/27-VI/14
		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня		
VI сар	УШ						1	2		
	УШ	3	4	5	6	7	8	9	Бакалаврын мэргэжлийн хөтөлбөр сонголт	VI/17-VI/21
	УШ	10	11	12	13	14	15	16	Нэгтгэн дүгнэх	
	УА	17	18	19	20	21	22	23	Зуны амралт	

		24	25	26	27	28	29	30		

ЯШ- Явцын шалгалт
УШ-Улирлын шалгалт

НД- Нэгтгэн дүгнэх
УА- Улирлын амралт

худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн товч түүх

Манай улсын ууган сургуулиудын нэг болох Хоршооны түр сургууль 1924 онд байгуулагдсанаар одоогийн Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн тулгын чулуу тавигджээ. Тус сургууль нь Монголын худалдаа, нийтийн хоол, түүхий эд бэлтгэлийн 40 гаруй мянган мэргэжилтэн бэлтгэсэн эрдмийн нэгэн уурхай билээ. ХҮИС нь:

- * 1924 онд Хоршооны түр сургууль
- * 1938 онд Худалдааны техникум
- * 1991 онд Зах зээлийн коллеж
- * 1996 онд Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургууль
- * 2010 онд МУИС Худалдааны сургууль
- * 2013 онд МУИС-ийн Бизнесийн сургууль
- * 2017 онд Худалдаа Үйлдвэрлэлийн их сургууль

болж өргөжин хөгжсөн түүхэн замналтай.

Өнөөдөр тус сургууль:

- ☉ 30 шахуу анги кабинет бүхий хичээлийн 2 байр, 420 оюутан амьдрах дотуур байр, 40 мянга гаруй ном бүхий фонд, уншлагын 2 танхим, 300 гаруй оюутан хичээллэх лекцийн их танхим, орчин үеийн компьютерээр тоноглогдсон 2 лаборатори, улсын хэмжээний уралдаан тэмцээн явуулах боломж бүхий спорт заал, өнөөгийн шаардлагад нийцэхүйц 2 цайны газар, байгалийн үзэсгэлэнт “Туул голын” хөвөөн дээр байрласан “Харзтай”-н амралт, “Хөвсгөл усан зам” аялал жуулчлалын

газартай. 2002 онд Баянхонгор аймагт салбар сургуулиа нээсэн.

✿ 26 багштай, тэдний 38,5 хувь нь доктор цолтой.

Нийт 478 гаруй оюутантай бөгөөд бакалаврын өдөр, орой, магистрантур, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг.

✿ **ХҮИС-ийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

- 2000 онд анхан шатны магадлан итгэмжлэл
- 2007 онд 2 дахь шатны магадлан итгэмжлэл
- 2009 онд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд “Худалдааны менежмент” мэргэжлээр

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдлэг, ур чадвараа нийгмийн баялгийг бүтээхэд зориулах худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн салбарын шинийг санаачлагч, хөрвөх чадвартай манлайлагчдыг бэлтгэх, нийгэм, эдийн засгийн салбарт судалгаа, шинжилгээний чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино.

АЛСЫН ХАРАА

2025 он гэхэд худалдаа, үйлчилгээний технологи, бизнесийн сургалт, судалгааны түшиц Монгол улсдаа тэргүүлэх их сургууль болоход оршино.

Мэдээлэл, ном сурах бичиг, багшлах бүрэлдэхүүний хүрэлцээ, хангамж, чанарыг сайжруулах, ажиллах, суралцах таатай орчинг бүрдүүлэх нь манай сургуулийн стратегийн зорилго билээ.

Бид өнгөрсөн хугацаанд эрхэм зорилгодоо нийцүүлэн жил бүрийн зорилго, зорилтуудаа тодорхойлон хэрэгжүүлж ирэв.

☉ Сургуулийн захирал, дэд захирал, мэргэжилтнүүд

Захирал: Доктор(Ph.D), профессор М.Должин

Захирлын туслах: Р.Ононцэцэг

Өрөө: II байр, 205 тоот, Утас: 75118989-200

Захирал нь сургуулийн амьдралын дараах асуудлыг хариуцна.

- ☉ Сургуулийн өдөр тутмын ажлуудыг зохион байгуулж удирдах;
- ☉ Төсөв, санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт ба зарцуулалтанд хяналт тавих;
- ☉ БСШУЯам болон удирдах зөвлөлийн шийдвэр, заавар удирдамжийг үндэс болгон ажиллах;
- ☉ Сургуулийн эрдмийн зөвлөлийг удирдах;
- ☉ Төсвийн гадуурхи хөрөнгийн эх үүсвэр олох, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх;
- ☉ Ажилтнуудыг ажилд авах, солих, өөрчлөх асуудлыг мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллах.

Д/д	Ажилтнууд	Овог нэр	Өрөө	Утас
1	Сургалтын албаны дарга	У.Мягмарсүрэн	II байр 308 тоот	75118989-202
2	Дэд захирал	Г.Алтанзаяа	II байр 401 тоот	
3	Корпораци, инновацийн төвийн эрхлэгч	Н.Отгонсайхан	II байр 403 тоот	75118989-204
4	Гадаад харилцааны мэргэжилтэн	С.Ардак	II байр 306 тоот	

☉ Сургалтын алба

Дарга: У.Мягмарсүрэн

Өрөө: II байр, 308 тоот, Утас 75118989-202

Оюутны бүртгэл, дүн, тооцоо хариуцсан ахлах

мэргэжилтэн: Д.Отгонцэцэг

Хичээлийн зохицуулалт, хяналт

хариуцсан мэргэжилтэн: О.Одсүрэн

Сургалтын алба нь:

- ☉ Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх;
- ☉ Сургалт зохион байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг хангах;
- ☉ Хичээлийн зохицуулалт хийж, хяналт тавих;
- ☉ Сургалтын ажлын бүртгэл, тооцоо хийх;
- ☉ Сургуулийн удирдлага, багш, оюутныг шаардлагатай мэдээллээр хангах;
- ☉ Оюутны мэдлэг үнэлэх ажлыг зохион байгуулах зэрэг үндсэн үүрэгтэй.

☉ Санхүүгийн алба

Ерөнхий нягтлан бодогч: Ц.Цэрэнлхам

Нягтлан бодогч: Н.Зул-Эрдэнэ

Өрөө: II байр, 200 тоот, Утас:75118989-201

Ерөнхий нягтлан бодогч нь:

- ☉ Сургуулийн санхүүгийн болон нягтлан бодох бүртгэл, тооцооны ажлыг хариуцан эрхлэх;
- ☉ Сургалтын төлбөрийн тооцоог оюутан бүрээр жилийн хичээл сонголтын нийт кредитэд үндэслэн хийх;

- ☼ Төрийн сангийн гэрээгээр суралцдаг оюутнуудын гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;
- ☼ Төсвийн болон өөрийн орлого, зарлагын байдлыг тооцож, багш, ажилчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг тухай бүр тооцож байх;
- ☼ Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын

төслүүдийг

холбогдох байгууллагаар батлуулан, санхүүжилт хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллана.

🌀 Оюутны зөвлөл


Зөвлөлийн дарга: Б.Мөнхбат

Өрөө: I байр, 116 тоот

Суралцаж буй оюутнуудын эрх ашгийг хамгаалж, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Оюутны зөвлөл нь нийт 12 гишүүнтэй.

Тус зөвлөл нь сургууль болон мэргэжлээ сурталчлах зорилгоор танин мэдэхүй, хэвлэл мэдээлэл, бизнесийн харилцааны болон соёл хүмүүжлийн зэрэг клубүүдийг ажиллуулдаг. Мөн урлаг, уран сайхан, спортын олон төрлийн арга хэмжээг зохион байгуулахад туслалцаа үзүүлдэг.

❖ Мэргэжлийн тэнхим, төв, салбарууд



Тэнхим, салбарын эрхлэгч нь:

- ☼ Сургууль, тэнхимийн өмнө тавигдаж буй сургалтын агуулга, технологийн арга зүйг боловсронгуй болгох;
- ☼ Тэнхимийн багшлах боловсон хүчний хэрэгцээг тооцох, багшийг сонгон шалгаруулахад оролцох;
- ☼ Өөрийн тэнхимд харъяалагдах суралцагчдын мэргэжил сонголтонд туслах, бие даах ажилд хяналт тавих;
- ☼ Сургалтын төлөвлөгөөг сайжруулах, төлөвлөх, стандартыг хангах ажлыг хэрэгжүүлэх;

- ☼ Өөрийн тэнхим, салбарын сургалтын үйл явцад хяналт тавьж, судалгаа явуулж, дүгнэлт өгөх;
- ☼ Багш нарын хичээл заах ур чадварыг дээшлүүлэх, судалгааны ажил хийхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг үүрэгтэй.

Тэнхимүүдийн бэлтгэн гаргаж буй мэргэжил

Д/д	Тэнхим салбар, төв	Өрөө	Утас	Бэлтгэх мэргэжлийн чиглэл
1.	Ерөнхий эрдмийн тэнхим	II байр, ¹ 307		Эдийн засаг, Сэтгэл судлал
2.	Гадаад хэлний тэнхим	II байр, ¹ 306		
3.	Мэргэжлийн тэнхим	II байр, ¹ 403		НББ, Худалдаа, Маркетинг, Менежмент, Санхүү, Банк, Даатгал, Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээ
4.	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	I байр, ¹ 111		Хангамжийн нярав, Компьютерийн оператор-албан хэргийн ажилтан, Нягтлан бодох бүртгэл, тооцооны ажилтан, Тогооч

ОЮУТАН СУРАЛЦАГЧИЙН ЁС ЗҮЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Монгол улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Боловсролын тухай хууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн дүрэм, дотуур байрны журам, оюутны тангараг, эрхэмлэх зүйл, оюутантай байгуулсан сургалтын гэрээ, МОХ-ны ёс зүйн дүрэмд нийцсэн байна.

1.2. Тус журмаар ХҮИС-ийн оюутан суралцагчийн ёс зүйн харилцааг зохицуулна.

1.3. ХҮИС нь ардчилал, хүний эрхийг дээдлэн, аливаа хүчирхийлэл, сүрдүүлгээс ангид байж оюутны суралцах таатай орчныг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллана.

Хоёр. Оюутны ёс зүйн зарчим

2.1. ХҮИС-ийн оюутан нь Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм, журмын заалт, сургалтын гэрээгээр хүлээсэн үүрэг, ёс зүйн энэхүү дүрмийг чанд сахих;

2.2. Сургуулийнхаа эрхэм зорилгыг дээдлэн хүндэтгэж, шинжлэх ухаанд шамдан суралцаж, эх орныхоо хөгжил дэвшилд өөрийн хувь нэмэр оруулах эрмэлзэлтэй шилдэг оюутан суралцагч байх;

2.3. Эрдэмтэн багш, ажилтан хамт олноо хүндэтгэн, нийгэм хамт олны үйлсэд өөрийгөө зориулдаг байх;

2.4. Сургуулийнхаа материаллаг бааз анги танхим дотуур байрны эд хөрөнгийг ариг гамтай ашиглах;

2.5. Хамт суралцаж буй бусад оюутнуудад ямар нэгэн дарамт шахалт саад хийхгүй нөхөрсөг хандан тусалж дэмжин хамтарч байх;

2.6. ХҮИС-ийн оюутан дээрх үндсэн зарчмуудаас гадна, нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээ,

суралцаж байгаа мэргэжлийнхээ ёс зүйн зарчмуудыг сахих.

Гурав. Ёс зүйн зөрчилд хамрагдах үйлдэл

3.1. Ёс зүйн зөрчил гэдэг ойлголтод ёс зүйн үндсэн зарчмуудад болон нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан үйлдлийг хамруулан авч үзнэ.

3.2. Оюутны ёс зүйн зөрчилд дараах зүйлийг хамруулна. Үүнд:

3.2.1. ХҮИС-ийн эрхэм зорилго, нэр хүндийг гутаах, үл хүндэтгэх, сургуулийн захиргааны шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийх;

3.2.2. Багш ажиллагсад оюутны биед халдах, үл хүндэтгэн дайрч доромжлох, нэр төрийг нь сэвтүүлэх оролдлого хийх;

3.2.3. Бусдыг дарамталж сүрдүүлэх, эрх чөлөө, хувийн нууцад нь халдах, хамт суралцаж буй оюутнуудынхаа сурч боловсрох, амгалан тайван амьдрах эрхэд санаатайгаар саад учруулах;

3.2.4. ХҮИС-ийн хичээлийн болон оюутны байр, сургуулийн дэвсгэр нутагт архидан согтуурах, мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, тусгайлан зөвшөөрснөөс бусад орчинд тамхи татах, нус цэр, шүлсээ хаях, хог тарих;

3.2.5. ХҮИС-ийн улирал, улсын шалгалтын журам зөрчих, шалгалтын материалыг санаатайгаар задлах, тараах, хичээлийн дүнг өөрчлөх, засвар хийх, хуурамчаар үйлдэх зэргээр сурлагын дүнгийн үнэлгээнд зүй бус үйлдэл гаргах;

3.2.6. Багш, ажилтан болон эрх бүхий бусад хүмүүст хандан өөртөө ашигтай шийдвэр гаргуулахаар авилгал, хээл хахууль өгөх буюу өгөхийг завдах;

3.2.7. Ёс зүйн зөрчил гаргасан этгээдийг мэдсэн атлаа түүнийг нь нуун дарагдуулах, өмөөрч хаацайлах;

3.2.8. ХҮИС-ийн хичээлийн болон дотуур байрны эд хогшлыг санаатайгаар эвдэх, устгах, өнгө үзэмж, чанарыг ноцтойгоор алдагдуулах;

3.2.9. Нийгмийн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан аливаа үйлдэл хийх.

Дөрөв. Ёс зүйн зөрчил гаргасан оюутанд хүлээлгэх хариуцлага

4.1. Ёс зүйн зөрчил гаргасан оюутанд зөрчлийн хэр хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан ХҮИС-ийн захиргаанаас доорх хариуцлагыг хүлээлгэнэ.

4.1.1. Амаар буюу бичгээр анхааруулга, сануулга өгч уучлал гуйлгах;

4.1.2. Учруулсан хохирлыг төлүүлэх;

4.1.3. Тус сургуулийн оюутан байх эрхийг хасах.

4.2. Сануулга өгч уучлал хүсүүлэх хариуцлагыг ёс зүйн хөнгөн зөрчил гаргасан этгээдэд ногдуулах ба хичээлийн нэг жилийн хугацаанд оюутанд нэгээс илүү ногдуулахгүй.

4.3. ХҮИС-ийн оюутан байх эрхийг хасах хариуцлагыг ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан буюу давтан ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд ёс зүйн хувьд сургуульд тэнцэхгүй хэмээн үзэж уг хариуцлагыг хүлээлгэнэ.

4.4. Сургуулиас болон дотуур байрнаас хасагдах шийтгэл хүлээсэн этгээдэд сургалтын, дотуур байрны төлбөрийг нь буцаан олгохгүй бөгөөд энэ дүрэмд ёс зүйн зөрчил гэж заасан үйлдлүүдийг мэдээгүй байсан нь хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.

Тав. Ёс зүйн зөвлөл

5.1. ХҮИС нь дэргэдээ оюутны ёс зүйн зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хамт олон, оюутны байгууллагын саналыг үндэслэн захирлын тушаалаар батална.

5.2. Оюутны ёс зүйн зөвлөлд ХҮИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал хяналт тавина.

5.3. Оюутны ёс зүйн зөвлөл нь дарга, гишүүдтэй байх ба ХҮИС-ийн оюутны зөвлөлийн тэргүүн, оюутны

хяналтын зөвлөлийн дарга, сургуулийн удирдах зөвлөлд байгаа багш нарын төлөөллөөс тус тус бүрдэнэ.

5.4. Оюутны ёс зүйн зөвлөл нь ХҮИС-д суралцагч оюутнуудын ёс зүйн зөрчлийг магадлан судалж, дүгнэлт гарган, сургуулиас хасуулахаас бусад тохиолдолд шийдвэр гаргах, сургуулиас хасах саналтай бол захиргааны зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

5.5. Тус журмын 4.3.-т заасан шийтгэл ноогдуулах асуудлыг захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулна.

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ТАНГАРАГ, ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛ

ХҮИС-ийн оюутны тангараг

Худалдаа, Үйлдвэрлэлийн Их Сургуулийн оюутан би шинжлэх ухааны арвин их мэдлэгийг эзэмшихийн төлөө оюун ухаан, бие бялдар, авьяас чадвараа дайчлан, ёс зүйг эрхэмлэн суралцахаа батлан тангараглая.

ХҮИС-ийн оюутны эрхэмлэх зүйл

1. Эрдэм номын шимийг хүртэн, өөртөө итгэлтэй байж, Монгол орноо хөгжүүлэх их үйлсийн эгнээнд нэгдэцгээе.
2. Юмс үзэгдлийн мөн чанар, зүй тогтлыг танин мэддэг Монгол уламжлалыг шинжлэх ухаан, эрдмээр баяжуулж, цагийн үнэ цэнэ, амьдрахуйн ухаанд шамдан суралцацгаая.
3. Хууль, тогтоомж, шударга ёсыг дээдлэн оюутны ёс зүйн дүрмийг чандлан сахиж, ахмад үе, сургууль, багш, хамт олноороо бахархан эвтэй найртай сурч амьдарцгаая.
4. Сонгосон мэргэжлээрээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг мэргэжилтэн болцгооё.

5. Үндэсний тусгаар тогтнол, түүх, соёл, ёс жудгаа дээдлэн, эх орныхоо хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулцгаая.

ОЮУТАНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ:

1. Сургалтын үйлчилгээ

Магистрантурын сургалт: /1,5 жил/

- ☼ Нягтлан бодох бүртгэл
- ☼ Худалдаа
- ☼ Хэрэглээний математик
- ☼ Аялал жуулчлалын менежмент
- ☼ Зочлох үйлчилгээ

Бакалаврын өдрийн сургалт: /4 жил/

- ☼ Эдийн засаг /Эдийн засаг-Математик загварчлал, Эдийн засаг-Мэдээлэл зүй/
- ☼ Нягтлан бодох бүртгэл /НББ-хяналт шалгалт, татвар, НББ-мэдээлэл зүй/
- ☼ Худалдаа /Худалдаа, Олон улсын худалдаа, Гаалийн удирдлага/
- ☼ Маркетинг /Маркетинг, Рекламны менежмент/

- ☼ Санхүү, банк /Санхүү, Банк/
- ☼ Даатгал /Даатгалын эдийн засаг/
- ☼ Эрх зүй /Бизнесийн эрх зүй/
- ☼ Менежмент /Хүний нөөцийн менежмент, Үйлдвэрлэлийн менежмент/
- ☼ Аялал жуулчлалын менежмент
- ☼ Зочлох үйлчилгээ
- ☼ Сэтгэл зүй /Бизнесийн сэтгэл судлал/

Бакалаврын орой, эчнээ сургалт: /2-3 жил/

- ☼ Нягтлан бодох бүртгэл
- ☼ Худалдаа
- ☼ Зочлох үйлчилгээ

Бакалаврын өдрийн сургалт: /бакалаврын түргэвчилсэн сургалттай НББ-ийн анги 2 жил, баасан, бямба гаригт хичээллэнэ./

- ☼ Нягтлан бодох бүртгэл

Мэргэжлийн сургалт: /1 жил/

- ☼ Нярав, Худалдаа хангамжийн
- ☼ Компьютерийн операторч-Албан хэргийн ажилтан
- ☼ Бүртгэл тооцооны туслах ажилтан
- ☼ Тогооч
- ☼ Зоогийн газрын үйлчилгээний ажилтан

2. Номын сангийн үйлчилгээ

Эрхлэгч: Ц.Бадмаа Утас:

Номын санч: Б.Туул, Э.Энхмаа

Номын сан, мэдээллийн үйлчилгээний төвийн ажилтнууд нь багш, ажилтан, оюутан, суралцагсдыг шаардлагатай ном сурах бичиг, тогтмол хэвлэл, номын сантай холбоотой мэдээллээр хангах үндсэн үүрэгтэй.

Номын сан нь 40 мянга шахам ном бүхий фондтой.

Оюутны уншлагын танхим /II байр 310 тоот өрөө/, Эрдэм шинжилгээний уншлагын танхим /II байр 104 тоот өрөө/, Гэрээр ном олгох фонд / II байр 107 тоот өрөө / тодорхой хуваариар оюутнуудад ном, сурах бичиг, мэргэжлийн сонин сэтгүүлээр үйлчилдэг.

nucb.lib4u.net - е каталогийн хаяг.

Номын сангуудын ажиллах цагийн хуваарь

	<i>Сургалтын уншлагын танхим /Хичээлийн 2-р байрны III давхарт/</i>	<i>Эрдэм шинжилгээний уншлагын танхим /2-р байрны I давхарт/</i>	<i>Гэрээр ном олгох фонд /2-р байрны IY давхарт/</i>
<i>Даваа</i>	9.00-18.00	8.00-19.00	9.00-18.00
<i>Мягмар</i>			
<i>Лхагва</i>			
<i>Пүрэв</i>			
<i>Баасан</i>			
Бямба	Амарна	Амарна	Амарна
Ням			
Цайны цаг	13.00-14.00	-	-
Дотоод ажил, Их цэвэрлэгээний өдөр	Сар бүрийн сүүлийн 7 хоногийн <u>лхагва</u> гарагт		

Жич: Сургалтын болон Эрдэм шинжилгээний уншлагын танхим нь 7 хоног тутам үдээс хойш буюу урагш ээлжинд солилцон ажиллана.

3. Компьютерийн үйлчилгээ

☼ Тус сургуулийн бүх тэнхим, нэгжүүд орчин үеийн өндөр хүчин чадал бүхий компьютерээр бүрэн тоноглогдсон.

4. Оюутны дотуур байрны үйлчилгээ

Оюутны байрны багш: С.Туяа

Утас:

420 оюутан суух оюутны тохилог байртай. Нэг оюутанд 5,45 м² талбай ноогддог.

Уншлагын заал, эцэг эхчүүдэд үйлчлэх өрөөтэй. Оюутнууд халуун ус, таксфоноор үйлчлүүлдэг.

5. Багш, оюутанд үйлчлэх цайны газар:

Өрөө: I байр, 107 тоот, II байр 108 тоот - “Бэнто”

Оюутнуудад өдрийн цагаар хоолны үнийн тодорхой хувийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлж, буцалсан ус үнэгүй түгээгддэг.

6. Бусад үйлчилгээ / амралт/

Биеийн тамир, спортын заал: Хичээл II байр, I давхарт. 500 м² талбай бүхий биеийн тамирын заалтай.

Дасгалжуулагч багш Ж.Отгондарийн удирдлага дор хичээллэдэг сагсан бөмбөгийн багийн тамирчид Монголын бүх ард түмний спартакиадын аварга, Оюутны улсын аваргын 4 удаагийн, Оюутны лигийн 2 удаагийн аварга баг болсон. Оюутнууд чөлөөт цагаараа чийрэгжүүлэх болон аэробикийн дугуйланд хичээллэх боломжтой.

"Харзтай"-н амралт: Улаанбаатар хотоос 60-аад км-т байгалийн үзэсгэлэнт "Туул" голын хөвөөн дээр оршдог.

"Хөвсгөл-усан зам - (Сүхбаатар хөлөг онгоц)":

Эдгээр газрууд нь оюутны дадлагын бааз бөгөөд багш оюутнууд хөнгөлттэй үнээр амардаг.

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журам, Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль (цаашид ХҮИС гэнэ)-ийн дүрмийг үндэслэн ХҮИС-д бакалаврын болон магистрын зэрэг олгох сургалт зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2 Бакалаврын зэрэг олгох сургалтын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнд хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, тэднийг бүтээлч сэтгэлгээтэй, ёс зүйтэй, эерэг зөв хандлагатай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

1.3 Магистрын зэрэг олгох сургалтын зорилго нь бакалаврын зэрэгтэй иргэнд сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, инновацийн ахисан түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, түүнийгээ бие даан бүтээгдэхүүн болгон хөрвүүлдэг, ёс зүйн төлөвшилтэй, магистрын зэрэгтэй, эерэг зөв хандлагатай мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино.

1.4 Өмнө эзэмшсэн бакалаврын мэргэжлээс өөр чиглэлээр магистрын хөтөлбөрт элсэн суралцахыг хүссэн иргэдэд зориулсан сургалтын агуулгын залгамж, чанарыг хангахад чиглэсэн магистрын нөхцөлт хөтөлбөр байж болох бөгөөд агуулга, цагийн багтаамж зэрэгт тавигдах шаардлагыг тэнхим, сургалтын албатай хамтран шийдвэрлэнэ.

1.5 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал ХҮИС-ийн захиргааны зөвлөл хэлэлцэж, захирал шийдвэр гаргана.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1 Хөтөлбөр (Curriculum). Хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа) тодорхой шатны боловсролын зэрэг (degree) олгоход нийцүүлсэн суралцагчийн суралцах хөтөлбөр¹.

2.2 Үндсэн мэргэжлийн хөтөлбөр (Major). Оюутны суралцах үндсэн мэргэжлийн чиглэл буюу тухайн шинжлэх ухааны тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр бакалаврын түвшинд эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

2.3 Хавсарга мэргэжлийн хөтөлбөр (Minor). Үндсэн мэргэжлийн зэрэгцээ өөр мэргэжлийн чиглэлээр системтэй мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

2.4 Хос мэргэжлийн хөтөлбөр (Double Major). Үндсэн мэргэжлийн зэрэгцээ хоёр дах мэргэжлийг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

2.5 Гүнзгийрэн мэргэжих (Track). Үндсэн мэргэжлийн тодорхой чиглэлээр гүнзгийрэн судлах багц хичээл.

2.6 Сургалтын төлөвлөгөө. Судлах хичээлийн жагсаалт, агуулгын багтаамж, дараалал, дадлагын төрлийг тусгасан баримт бичиг.

2.7 Хичээлийн хөтөлбөр нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн индекс, суралцагчийн эзэмшвэл зохих онолын ба практик мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багтаамж/багц цаг, ашиглавал зохих

ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг.

2.8 Хичээлийн индекс. ХҮИС-д заах бүх хичээл нэгдсэн кодтой байх ба өөр хоорондоо давхцахгүй. Код нь тухайн хичээлийн нэрний эхний 4 үсэг (англиар) болон 3 оронтой тооноос бүрдэнэ. 3 оронтой тооны эхний орон уг хичээлийн түвшнийг, дараагийн хоёр орон тухайн хичээлийн дугаар (хичээл хоорондын уялдаа холбоо, эрэмбэ дарааллыг харгалзан тогтооно)-ыг заана. Үүнд:

- ✓ 001-099 дугаартай бол өмнөх түвшний хичээл (Бакалаврын үндсэн кредит цагт тооцохгүй)
- ✓ 100-199 дугаартай бол ерөнхий суурь хичээл
- ✓ 200-499 дугаартай бол бакалаврын хөтөлбөрийн хичээл
- ✓ 500-599 дугаартай бол магистрын суурь хичээл (бакалавр болон магистрын хөтөлбөрийн суралцагчид хамт үзэж болох хичээл)
- ✓ 600-699 дугаартай бол магистрын мэргэших хичээл
- ✓ 700-799 дугаартай бол магистр болон докторын хөтөлбөрийн суралцагчид хамт үзэж болох хичээл ба докторын суурь хичээл болно.

2.9 Заавал судлах (Compulsory) хичээл. Тухайн хөтөлбөрийн зайлшгүй судлах хичээл.

2.10 Сонгон судлах (Elective) хичээл. Тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүлэг бүрээр авбал зохих багц цагийг судлах зорилгоор тодорхой бүлэг хичээлүүдээс суралцагч өөрөө сонгон судлах хичээл.

2.11 Ерөнхий суурь (General Education) хичээл. Оюутанд дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндэс, олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэхийн зэрэгцээ төрөлх болон гадаад хэлээр зөв ярих, бичих, харилцах, үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах, тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах чадвар эзэмших зорилго агуулсан бүлэг хичээл.

2.12 Мэргэжлийн суурь (Core) хичээл. Суралцагчид суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгох, тухайн талбарт асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээл.

2.13 Мэргэжлийн хичээл (Major course). Тодорхой мэргэжлийн мэдлэг ур чадвар өгөхөд чиглэсэн, оюутанд шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэл, салбараар төвлөрч, гүнзгийрэн судлах боломж олгодог заавал болон сонгон судлах хичээл.

2.14 Чөлөөт сонголт (Free elective)-ын хичээл. Суралцагч өөрийн хүсэл, сонирхлоор сонгох боломжтой ХҮИС-аас санал болгож байгаа зэрэгцүүлэн судлах боломжтой бүх хичээл. Тухайн сонгож буй хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

2.15 Залгамж (Prerequisite) хичээл. Тодорхой хичээлийг судлахаас өмнө амжилттай судалсан байвал зохих хичээл.

2.16 Зэрэгцүүлэн судлах (Corequisite) хичээл. Тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судлаж болох хичээл.

2.17 Хичээлийн цаг. 45 минут байх ба хоёр цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно.

2.18 Багц цаг (Credit) нь боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд суралцагчийн сурах ачаалал, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тогтоох үндсэн хэмжүүр, дээд боловсролын зэрэг олгох сургалтад тавигдах нийтлэг шаардлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах үндэслэл болно. Нэг багц цагийн хэмжээ нь 16 долоо хоногтой 1 улиралд лекц 16 цаг, эсвэл семинар, лаборатори, практикийн 32 цаг байна.

2.19 Хичээлийн багц цаг нь хичээлийн агуулгыг илэрхийлэх бүхэл тоо байх бөгөөд хэмжээ нь улиралд

тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамаарна. Суралцагчийн нэг долоо хоногт сурах үйл ажиллагаанд зарцуулах дараах багц бүрийг нэг багц цаг гэж тодорхойлно. Үүнд:

- Лекцийн 1 цаг + суралцагчийн бие даан суралцах 2 цаг;
- Семинар, лабораторийн хичээл 2 цаг + суралцагчийн бие даан суралцах 1 цаг;
- Дадлага, бакалаврын судалгааны ажил зэрэг сургалтын бусад хэлбэрээр оюутны сурах үйл ажиллагаанд зарцуулах 48 цагийг нэг багц цагтай дүйцүүлж тооцно.

2.20 Суралцагчийн тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ. Хичээлийн хөтөлбөрт заасан эзэмшвэл зохих мэдлэг чадварыг суралцагч хэрхэн судалж эзэмшснийг илтгэх тоон болон чанарын үзүүлэлт. Үнэлгээ нь хэмжилтийн хувьд “оноо”, “дүн” (тоо болон үсгээр илтгэсэн дүн) гэсэн хэлбэртэй байна.

2.21 Оноо. Тухайн хичээлээр суралцагчийн хийж гүйцэтгэх ёстой болон бие даан суралцах үйл ажиллагааны гүйцэтгэл, эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшнийг 100% гэж үзэж үнэлсэн хувьчилсан тоо.

2.22 Дүн нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг илэрхийлэх (А, А-), (В, В-), (С, С-), (D, D-), F үсгээр тэмдэглэх үнэлгээ юм. Эдгээр дүнд тоогоор илтгэсэн (4.0, 3.6), (3.1, 2.7), (2.3, 1.9), (1.4, 1.0), 0 гэсэн дүнг харгалзуулна.

2.23 Явцын үнэлгээ. Тухайн хичээлийн явцад суралцагч хөтөлбөрийн дагуу эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшиж буйг үнэлж багш суралцагчийн сургах, сурах үйл ажиллагааг цаашид идэвхжүүлэх үзүүлэлт.

2.24 Улирлын шалгалт. Тухайн хичээлийг судалж дууссаны дараа суралцагч уг хичээлийн хөтөлбөрт заасан мэдлэг, ур чадварыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх гол үзүүлэлт.

2.25 Нэгдсэн шалгалт. Боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг бүрэн судалсан суралцагчийн тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь ХҮИС-ийн төгсөгчдөд тавих шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх гол үзүүлэлт.

2.26 Голч оноо. Багц цаг бүхий хичээл бүрээр суралцагчийн авсан оноог багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хуваасан (арифметикийн жинлэсэн дундаж) үзүүлэлт.

2.27 Голч дүн. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд голч онооны адил аргачлалаар бодно.

2.28 Бакалаврын судалгааны ажил. Бакалаврын хөтөлбөрийг дүүргэж буй оюутан тухайн үндсэн мэргэжлээр бакалаврын зэргийн дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшсэнээ баталгаажуулах, судалгаа шинжилгээний ажлын суурь мэдлэг, чадвараа хөгжүүлж, баталгаажуулах зорилгоор хийж болох судалгааны ажил юм.

2.29 Магистрын судалгааны ажил. Шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судалж туршилт, боловсруулалт, дүн шинжилгээг онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэсэн судалгааны ажил юм.

2.30 Элсэлтийн мэргэжлийн шалгалт. Төгсөлтийн дараах сургалт болон бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн мэдлэг, чадварыг тодорхойлох, цаашид тухайн түвшинд суралцах болон судалгааны ажил хийх чадвартай эсэхийг тодорхойлох ерөнхий шалгалт юм.

Гурав. Сургалтын удирдлага, зохион байгуулалт

3.1 Дээд боловсролын зэрэг олгох сургалтын ажлыг ХҮИС-ийн сургалтын алба удирдлагаар хангаж, зохион байгуулах ба Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, ХҮИС-ийн дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

3.2 Сургалтын албаны дарга ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг сургуулийн захирлын удирдлага дор хэрэгжүүлнэ.

3.3 Сургалтын албаны ажилтны ажлын байрны чиг үүрэг, тодорхойлолт, орон тоог сургалтын бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, суралцагч, хөтөлбөрийн тоо, ажлын ачааллаас хамааран сургалтын албаны даргын саналыг үндэслэн ХҮИС-ийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн батална.

3.4 Сургалтын алба нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

3.4.1 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сургуулийн удирдлагаас сургалтын үйл ажиллагааны талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах;

3.4.2 Сургалтын алба нь ХҮИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулах, суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажиллах;

3.4.3 Сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж, сургалтын тасралтгүй үйл ажиллагааг хангах;

3.4.4 Сургалтын үйл ажиллагаа болон суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийн холбогдох арга хэмжээг авах;

3.4.5 Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж дүгнэлт хийх;

3.4.6 Суралцагчийн мэдээлэл, батлагдсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн тодорхойлолтыг сургалтын мэдээллийн системд бүрэн, үнэн зөв оруулах;

3.4.7 Суралцагчдаар хичээл сонголтын тандалт хийлгэж, үр дүнд нь тулгуурлан багш нарын цагийн ачааллыг холбогдох тэнхимүүдээс авч хичээлийн хуваарь зохиох ба суралцагчийн хичээл сонголт, баталгаажуулалтыг заасан хугацаанд зохион байгуулах;

3.4.8 Судалгааны ажлын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавих.

3.5 Мэдээллийн технологийн ажилтан нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

3.5.1 Сургалтын мэдээллийн системийг ХҮИС-ийн сургалтын шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж сайжруулах;

3.5.2 Сургалтын мэдээллийн систем хэвийн ажиллах техник, технологийн нөхцлөөр хангах;

3.5.3 Сургалтын мэдээллийн систем, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах;

3.5.4 Сургалттай холбоотой стандарт ба стандарт бус статистик мэдээллийг сургалтын мэдээллийн системээс хэвлэж авах нөхцлөөр хангах;

3.5.5 Харилцагч банкуудын онлайн төлбөрийн хэвийн үйл ажиллагааг ерөнхий нягтлан бодогчтой хамтран хянаж, гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.6 Аж ахуйн менежер нь анги танхимын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаж хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.7 Тэнхмийн эрхлэгч нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

3.7.1 Багш нарын цагийн ачааллыг цаг тухайд нь сургалтын албанд гаргаж өгөх;

3.7.2 Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг батлагдсан дүрэм журам, зааврын дагуу боловсруулах, сайжруулах, хяналт тавих;

3.7.3 Баталсан хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалт явуулах;

3.7.4 Суралцагчдыг цаг хугацаанд нь бодитой үнэн, зөв үнэлж, дүнг цаг тухайд нь сургалтын мэдээллийн системд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих;

3.7.5 Эрдэм шинжилгээний хурал, семинар зэрэг суралцагчдын дунд зохиогдох эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах;

3.7.6 Хичээлийн хэвийн үйл ажиллагаа, багш профессорын хичээлийн болон зөвлөгөө өгөхөд цаг баримтлах явц, суралцагчийн хичээлийн оролцоонд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

3.7.7 Суралцагчдын дүнд статистик боловсруулалт хийж үр дүн дээр нь үндэслэн хичээлийн чанарт хяналт тавьж сайжруулах;

3.7.8 Багш, ажилтныг хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмж, бусад шаардлагатай эд зүйлсээр хангах;

3.8 Ерөнхий нягтлан бодогч сургалтын төлбөртэй холбоотой асуудлыг холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах ба сургалтын төлбөр, бүртгэлийн хураамжтай холбоотой мэдээллийг сургалтын мэдээллийн системд цаг тухайд нь оруулж, тайлан гаргах.

3.9 Гадаад харилцааны мэргэжилтэн нь ХҮИС-ийн гадаад хамтын ажиллагааны бүхий л асуудлыг хариуцан ажиллана.

Дөрөв. Сургалтын хөтөлбөр

4.1 Сургалтын хөтөлбөр нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан, дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.2 Хөтөлбөрт ерөнхий танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа болон бусад нэмэлт шаардлага багтана.

4.3 Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн агуулга, шаардлага

4.3.1 Дээд боловсролын Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь

“Ерөнхий суурь”, “Мэргэжлийн суурь”, “Мэргэжлийн”, “Чөлөөт сонголт” гэсэн бүтэцтэй байх ба тус журмын 2.9-2.16-д заасан агуулга зорилготой.

4.3.2 Бакалаврын зэрэг авахад шаардагдах хамгийн доод хэмжээ нь 120 багц цаг бөгөөд цагийн хуваарилалт дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Ерөнхий суурь – 30 багц цаг
- ✓ Мэргэжлийн суурь – 21 багц цаг
- ✓ Мэргэжлийн – 54 багц цаг
- ✓ Чөлөөт сонголт – 15 багц цаг

4.3.3 Бакалаврын орой, эчнээ хэлбэрээр суралцах дээд боловсролын бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын түвшинд эзэмшсэн мэргэжил болон суралцах мэргэжлээсээ хамааран 75 багц цагийг цуглуулна.

4.3.4 Ерөнхий суурь хичээлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шаардлагад нийцүүлэн дараах бүтцээр судална. Үүнд:

- ✓ Байгалийн ухаан – 3 багц цаг
- ✓ Хүмүүнлэгийн ухаан – 6 багц цаг
- ✓ Нийгмийн ухаан – 3 багц цаг
- ✓ Иргэний боловсрол – 3 багц цаг
- ✓ Судалгаа шинжилгээний арга зүй – 3 багц цаг
- ✓ Яриа, бичгийн ур чадвар – 3 багц цаг
- ✓ Англи хэл, бусад хэл – 6 багц цаг
- ✓ Биеийн тамирын, эрүүл ахуй – 3 багц цаг

4.3.5 Оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулах бөгөөд тус журманд заасны дагуу ерөнхий суурийн хичээлийн тодорхой багц цагийг амжилттай судалсны дараа мэргэжлийн хөтөлбөр сонгуулна.

4.3.6 Мэргэжлийн суурь, Мэргэжлийн болон Чөлөөт сонголтын хичээлийг тэнхимийн саналыг үндэслэн захиргааны зөвлөлөөр хэлэлцэж батална.

4.4 Магистрын зэрэг олгох хөтөлбөрийн агуулга, шаардлага

4.4.1 Магистрын хөтөлбөр нь мэргэжлийн тэнхим болон хөтөлбөрийн шаардлагад үндэслэх ба ерөнхий суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх, чөлөөт сонголтын

хичээл, эрдэм шинжилгээний болон магистрын ажил (судалгааны), дадлага (мэргэжлийн) гэсэн бүтэцтэй байна.

4.4.2 Магистрын хөтөлбөр нь мэргэжлийн ба судалгааны магистр гэсэн хоёр чиглэлтэй байх ба хичээлийн багц цаг дараах байдлаар хуваарилагдана. Үүнд:

Хөтөлбөрийн агуулга	Судалгааны	Мэргэжлийн
Ерөнхий суурь хичээл, үүнээс: <ul style="list-style-type: none"> ✓ Судалгааны: судалгааны арга зүй ✓ Мэргэжлийн: харилцааны ур чадвар, мэргэжлийн гадаад хэл 	3 багц цаг	2 багц цаг 2 багц цаг
Мэргэжлийн хичээл	6 багц цаг	12 багц цаг
Мэргэшүүлэх хичээл, үүнээс: <ul style="list-style-type: none"> ✓ Судалгааны: 3 багц цаг чөлөөт сонгон ✓ Мэргэжлийн: 6 багц цаг чөлөөт сонгон 	8 багц цагаас доошгүй	12 багц цаг
Бусад, үүнээс: <ul style="list-style-type: none"> ✓ Судалгааны: Эрдэм шинжилгээний ажил ✓ Мэргэжлийн: Дадлага 	4 багц цаг	4 багц цаг
Магистрын ажил	9 багц цаг	0
Нийт багц цаг	30 багц цаг	32 багц цаг

4.4.3 Магистрын хөтөлбөрт тухайн чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшээгүй хүмүүст зориулсан нөхцөлт хөтөлбөр байна. Энэ хөтөлбөрийн нийт багц цаг 15-21 байх ба тухайн шинжлэх ухааны, мэргэжлийн бакалаврын түвшинд үздэг гол суурь хичээлүүдийг багтаах бөгөөд суралцагч аль болох бакалаврын оюутнуудтай хамт судлах боломжийг олгоно. Эдгээр хичээлийн багц цагийг

магистрын зэрэг олгох хөтөлбөрийн үндсэн хичээлд тооцохгүй.

Тав. Сургалтын үйл ажиллагаа

5.1 Элсэлт

5.1.1 ХҮИС-д оюутан элсүүлэх үйл ажиллагааг тухайн жил бүрийн элсэлтийн журмаар зохицуулах ба энэхүү журмаар шалгалт өгөх хичээлийн төрөл, босго оноог тогтоож, нийтэд зарлана.

5.1.2 Суралцагч авъяас, сонирхолдоо нийцсэн мэргэжил, сургуулиа сонгох зэрэг тодорхой шалтгааны улмаас дотоод, гадаадын их дээд сургуулиас болон тус их сургуулийн аль нэг үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөс нөгөөд шилжин суралцаж болно. Энэ асуудлыг “Суралцагч шилжүүлэн суралцуулах” журмаар зохицуулна.

5.1.3 Бакалаврын өдөр, орой, эчнээ хөтөлбөрийн элсэлтийг жилд 1 удаа, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн элсэлтийг 1-2 удаа зохион байгуулна.

5.1.4 Бүрэн дунд боловсролтой, элсэлтийн ерөнхий шалгалтыг зохих журмын дагуу амжилттай өгч, элсэх эрх авсан, судлах хичээлээ сонгон баталгаажуулж сургалтын болон бусад шаардлагатай төлбөрийг төлсөн элсэгчийг ХҮИС-ийн бакалаврын хөтөлбөрт өдрөөр суралцуулахаар элсүүлнэ.

5.1.5 Бакалаврын зэрэгтэй, элсэлтийн шалгалтыг амжилттай өгч, элсэх эрх авсан, судлах хичээлээ сонгон баталгаажуулж сургалтын болон бусад шаардлагатай төлбөр төлсөн иргэнийг зарим хөтөлбөрөөр бакалаврын хөтөлбөрт орой, эчнээ хэлбэрээр суралцуулахаар элсүүлнэ.

5.1.6 Тухайн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, элсэлтийн шалгалтыг амжилттай өгч, бусад шаардлагыг биелүүлж элсэх эрх авсан иргэнийг ХҮИС-ийн магистрын хөтөлбөрт суралцуулахаар элсүүлнэ.

5.1.7 Уг журмын 4.4.3-т заасан магистрын нөхцөлт хөтөлбөрт суралцахыг хүссэн элсэгчид сургалтын агуулгын залгамж, чанарыг хангахад шаардагдах 15-аас дээш багц

цагийн хичээлийг мэргэжлийн тэнхим, сургалтын албаны зөвшөөрөл дээр үндэслэн судлах ба эдгээр хичээл дээр 70-аас дээш хувийн үнэлгээ авч байж үндсэн мэргэжлээр суралцах эрх үүснэ.

5.2 Сургалт

5.2.1 Оюутан тухайн улиралд судлах хичээлээ сонгож, сургалтын төлбөрийг төлснөөр суралцах эрхтэй болно.

5.2.2 Хичээлийн жил нь намар, хавар, зуны 3 улиралтай бөгөөд намар, хаврын улирал эхлэхээс өмнөх 7 хоногт тухайн улиралд судлах хичээлийн агуулгыг судлан танилцаж, хичээлд бүртгүүлэн баталгаажуулалт хийх тэг долоо хоногтой байна. Тэг долоо хоног нь танхимын сургалтын долоо хоногт орохгүй. Зуны улирал нь суралцагчийн саналыг үндэслэн, сургалтын албаны шийдвэрээр дадлага болон бусад хэлбэрээр явуулах сургалт байх бөгөөд хичээл, шалгалтыг оролцуулан 8 долоо хоногоос хэтрэхгүй байна.

5.2.3 Хичээлийн нэг улирал нь бакалаврын хөтөлбөрийн хувьд танхимын сургалтын хугацаа 16, шалгалтын 3 нийт 19 долоо хоног, магистрын хөтөлбөрийн хувьд танхимын 12, судалгааны 3, шалгалтын 1 нийт 16 долоо хоногтой байна.

5.2.4 ХҮИС-ийн бакалаврын түвшний хөтөлбөрийн хичээлд мэргэжлийн шаардлага хангасан иргэд сургалтын албанд хүсэлт гаргаж, сургалтын болон холбогдох үйлчилгээний төлбөр төлсний үндсэн дээр 15 багц цаг хүртэлх хичээлийг сонгон судалж болно. Иргэн хүсвэл ХҮИС-ийн оюутантай адил дүгнүүлж дүнгийн тодорхойлолт авч болно.

5.2.5 Ерөнхий суурийн англи хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр шалгалт өгч дүйцүүлэн тооцуулж болно.

5.2.6 Бакалаврын өдрийн хөтөлбөрийн хувьд оюутан улиралд дунжаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалвал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байна. Магистрын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 багц цагийн хичээл судлах нь

зохимжтой бөгөөд судалвал зохих багц цагийн дээд хэмжээ 12 байна.

5.2.7 Бакалаврын оюутны суралцаж буй түвшинг судалсан багц цагийн нийлбэрээр нь тогтооно.

Суралцах хэлбэр	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Өдөр	0-30	31-60	61-90	91 ба түүнээс дээш
Орой, эчнээ		0-30	31-60	61-90

5.2.8 Магистрын хөтөлбөрөөр элсэгчдийн судалгааны ажлын сэдэв, удирдагчийг хоёрдугаар улиралд багтаан захирлын тушаалаар батална. Эрдэм шинжилгээний ажлын багц цагийг эрдмийн зөвлөлийн шийдвэрт үндэслэн тооцно.

5.3 Хичээл, хичээлд бүртгүүлэх

5.3.1 Багш тухайн улирлын 12 дахь долоо хоногт дараагийн улиралд заах хичээлийн хүсэлтээ тэнхим, сургалтын албанд өгч баталгаажуулсан байна. Нэг хичээлийг хоёроос дээш багш заахаар төлөвлөж, суралцагчдад багшийг сонгох боломж олгох бөгөөд анги бүрдээгүй тохиолдолд илүү санал авсан багшаар тухайн хичээлийг заалгана.

5.3.2 Хичээлийн агуулгын стандарт, хувилбарыг тухайн хичээлийг зааж буй багш бүр мөрдөхийн зэрэгцээ мэдлэг, туршлагадаа тулгуурлан, судалж буй оюутнуудын мэргэжлийн онцлог, эрэлтэд нийцүүлэн, баяжуулан зааж болно.

5.3.3 Хичээлийг хэд хэдэн багш хамтран зааж болно. Хамтран заах тохиолдолд өмнөх улиралд багтаан тэнхимийн эрхлэгч сургалтын албанд хүсэлт гаргаж зөвшөөрсөн тохиолдолд заагдана.

5.3.4 Суралцагч тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлд санал

өгнө. Мэргэжлийн тэнхим тухайн хичээлд өгсөн саналыг үндэслэж 15, 16 дахь долоо хоногт багтаан хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, мэдээллийн системд байршуулан, сургалтын албанд баталгаажуулж өгнө.

5.3.5 Мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн сургалтын алба дараагийн улиралд орох хичээл, заах багшийн нэр, анги танхим, цаг бүхий хичээлийн хуваарийг улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно. Хичээлийн хуваарийг сургалтын албаны дарга батална.

5.3.6 Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн тухайн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлэх ба бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна.

5.3.7 Анги бүрдэлт бакалаврын хөтөлбөрийн хувьд гадаад хэл, биеийн тамирын хичээл 30, ерөнхий суурь лекцийн хичээл 50, ерөнхий суурь семинар, лабораторийн хичээл 25, мэргэжлийн суурь лекцийн хичээл 30, семинар, лабораторийн хичээл 15, магистрын хөтөлбөрийн хувьд 5 - аас доошгүй суралцагчтай байна.

5.3.8 Анги бүрдээгүй тохиолдолд өөр ижил төстэй хичээлийг тэнхимийн саналыг үндэслэн суралцагчид санал болгож болно.

5.3.9 Улирлын эхний долоо хоногт багтаан анги бүрдээгүйгээс суралцагчийн баталгаажуулсан хичээлийг цуцлах асуудлыг сургалтын алба шийднэ. Тухайн цуцалсан хичээлийг баталгаажуулсан багц цагийн төлбөрийг суралцагчийн дансанд буцаан байршуулж өөр хичээл сонгох эсвэл дараа улирлын төлбөрт шилжүүлэх боломжийг олгоно. Төгсөх ангийн суралцагч бөгөөд санхүүгийн тооцоогүй бол төлбөрийг буцаан олгоно.

5.3.10 Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Улирал эхэлснээс хойш таван долоо хоног өнгөрсөн бол бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй.

5.3.11 Сургалтын алба хичээл баталгаажуулалтын хугацаанд үүссэн аливаа асуудлыг журмын дагуу шийдвэрлэнэ.

5.3.12 Хичээлд бүртгүүлээгүй суралцагчийг багш хичээлд суулгаж дүгнэхийг хориглоно.

5.3.13 Эчнээ, орой хэлбэрээр суралцагч тухайн улирлын хичээл эхлэх өдрөөс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлж, баталгаажуулна.

5.3.14 Багш тухайн улиралд зааж буй хичээл тус бүрээр хуваарийн дагуу суралцагчид зөвлөгөө өгнө. Зөвлөгөө өгөхөд хичээл тус бүрээр долоо хоногт 90 минутыг зориулна.

5.3.15 Хөтөлбөрийн зөвлөх багшийг тухайн хичээлийн жилийн эхэнд сургуулийн захирлын тушаалаар томилно. Зөвлөх багш тухайн хичээлийн жилд элссэн оюутнуудыг төгсөх хүртэлх сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой зөвлөгөө өгнө.

5.4 Суралцагчийн ерөнхий үнэлгээ

5.4.1 Хичээлээр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгох бөгөөд үнэлгээ шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байна.

5.4.2 Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна.

5.4.3 Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг бодохдоо багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жинлэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot Д_i}{\sum_{i=1}^n K_i}$$

n - хичээлийн тоо

K_i - тухайн (i) дугаар хичээлийн багц цаг

$O_i (D_i)$ - тухайн (i) дугаар хичээлийн оноо (дүн)

$ГО(ГД)$ - голч оноо (голч дүн)

5.4.4 Суралцагч улирал бүр тухайн улирлын мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнтэйгээ танилцан, сурлагынхаа байдалд үнэлэлт дүгнэлт хийж цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.

5.4.5 Суралцагчийн голч оноо, голч дүнг улирал, хичээлийн жил, суралцсан хугацаа, мэргэжлийн хөтөлбөр, сургуулийн хэмжээнд суралцагчийг байр эзлүүлэхэд ашиглах буюу суралцагчийг шагнах, тэтгэлэг олгохоор тодорхойлох, төгсгөх, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт үргэлжлүүлэн сургах зэрэгт гол үзүүлэлт болгоно.

5.4.6 Семинар лабораторийн хичээл, судалгааны ажил бусад бие даалтын ажлаар олсон мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын хяналт, тест, ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашиглана.

5.4.7 Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээр хийх дадлагад багц цаг харгалзуулсан бол тэдгээрийн тайлангийн хамгаалалтыг шалгалтын нэгэн адил үзэж оноогоор үнэлнэ. Дадлагын тайланг холбогдох мэргэжлийн тэнхимийн дадлагын удирдамжийн дагуу хамгаалуулах ба оюутны дадлагын хичээлийг тусад нь журмаар зохицуулна.

5.5 Суралцагчийн тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ

5.5.1 Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа оюутны хичээлийн явцын идэвх оролцоо, бие даасан ажиллагааны завсрын хяналтын үнэлгээ, улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон “суралцагчийн мэдлэг, чадварыг оноогоор үнэлэх аргачлал” (Хавсралт 1)-ын дагуу 100 оноогоор үнэлнэ.

5.5.2 Хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан суралцагчийг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.

5.5.3 Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна. Үүнд:

